

МУИС, ШУС, БУС-ын Химийн тэнхимийн суралцагчдын дунд 2024-2025 оны хичээлийн жилд зохион байгуулагдах эрдэм шинжилгээний хурлын удирдамж

2025.02.26

Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын Химийн тэнхимийн 2024-2025 оны хичээлийн жилд Химийн тэнхимд суралцагчдын дунд явагдах эрдэм шинжилгээний хурал Бакалаврын болон Ахисан түвшин (АТ)-ий суралцагчид гэсэн 2 ангилалтайгаар 2025 оны **04 сарын 01**-ны өдөр МУИС-ийн хичээлийн 1-р байрны **324** тоот танхимд **11** цагт эхэлнэ.

МЭДЭЭЛЭЛ

Эрдэм шинжилгээний хуралд оролцох оюутан, АТ-ий суралцагчид, тэдэнтэй холбогдох багш нар илтгэгчийн нэр, сэдвийн мэдээллээ 2025 оны **03** сарын **24**-ний өдрийн **11** цаг хүртэл **b_sukhbaatar@num.edu.mn** хаягаар ирүүлнэ үү.

Хуралд оролцогчдын илтгэлийн хураангуйг эмхэтгэн тэнхимийн сайт дээр нийтэд түгээн дэлгэрүүлж танилцуулах зорилгоор байршуулна.

ХУРААНГУЙ

- Бүтээлийн буюу илтгэлийн хураангуйн агуулга, формат:

Бүх бичиглэл “Arial” фонт дээр 2 нүүрт багтаан бичигдэнэ.

Цаасны хэмжээ ба загвар:

- | | |
|--------------------------------------|---|
| 1. Цаасны хэмжээ | A4, 210 мм x 297 мм |
| 2. Захын зай – Margins | 4 талаас 2.0 см зайтай |
| 3. Цаасны дугаар | Баруун доод буланд, үсгийн хэмжээ 10 pt |
| 4. Хөл/Толгой - Footer/Header | Оруулахгүй. |
| 5. Гарчиг | Үсгийн хэмжээ 12 pt, өгүүлбэр эхэнд том үсэгтэй (Sentence case), тод (bold), голлуулна. |
| 6. Зохиогчид | Үсгийн хэмжээ 11 pt, налуу, зүүн дээд талд дугаарлана. |
| 7. Зохиогчдын харьяалал | Үсгийн хэмжээ 10 pt, налуу, зүүн талд доош дугаарлан жагсааж бичнэ. |
| 8. Түлхүүр үг | Үсгийн хэмжээ 9.0 pt, тодоор, 5 үгээс илүүгүй. |
| 9. Үндсэн бичвэр | Үсгийн хэмжээ 12 pt, өгүүлбэр эхэнд том үсэгтэй (Sentence case), мөр хоорондын зай 1.15 pt, |

Хураангуйг **04** сарын **01**-ны өдрийн **16** цаг хүртэл **b_sukhbaatar@num.edu.mn** хаягаар *.docx, *.pdf гэсэн өргөтгөлтэй хэлбэрүүдээр илгээнэ үү.

ИЛТГЭЛ

- Судалгааны ажлаа танилцуулах илтгэлийн хугацаа: **10 минут**

Илтгэлийн *.pptx өргөтгөлтэй файлыг **2025.03.28**-ны өдрийн **16** цагаас өмнө **b_sukhbaatar@num.edu.mn** хаягаар ирүүлнэ. Хугацаа хэтэрсэн бол хуралд **оролцуулахгүй** болохыг анхаарна уу.

Илтгэлийг дараах байдлаар бэлтгэнэ:

- 1) Удиртгал,
- 2) Материал,
- 3) Арга зүй,
- 4) Үр дүн, хэлэлцүүлэг,
- 5) Дүгнэлт
- 6) Ном зүй

Ном зүйг дараах форматын дагуу бичнэ.

Үүнд: өгүүлэл¹, диссертац (тесис)², ном³, патент (шинэ бүтээл, оновчтой санал, стандарт)⁴ хэлбэртэй байна.

1. Ling, R.; Yoshida, M.; Mariano, P. S. J. Org. Chem. 1996, 61, 4439–4449.
2. Goering, B. K. Ph.D. Dissertation, Cornell University, 1995.
3. Haslam, E. Shikimic Acid Metabolism and Metabolites, John Wiley & Sons: New York, 1993.
4. Buchanan, J. G.; Sable, H. Z. In Selective Organic Transformations; Thyagarajan, B. S., Ed.; Wiley-Interscience: New York, 1972; Vol. 2, pp 1–95.
5. Lyle, F. R. U.S. Patent 5 973 257, 1985; Chem. Abstr. 1985, 65, 2870.

Зураг оруулах: Хүснэгт, зураг, схем болон график багтана. Эдгээрийн тайлбар өгүүлбэрийн эхэнд том үсэгтэй байна (sentence case), үсгийн хэмжээ 10.0 pt, голлуулна. Жишээ нь:

Хүснэгт 1. Түүхий эдийн химийн найрлага

Зураг 1. Уусмалын pH, ионы идэвхийн хамаарал

ҮЗҮҮЛЭН ИЛТГЭЛ

- Бүтээлийн үзүүлэн илтгэл буюу постер: хэмжээ **80 см × 100 см** хэмжээтэй байхаар бэлтгэх ба **04** сарын **01**-ны өдрийн **15** цаг хүртэл **222** тоот өрөөнд авчирч өгнө үү.

АМЖИЛТ ХҮСЬЕ!

Суралцагчдын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах комисс